

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 01  
Тендер шалгаруулалтын нэр: *Дээж сугалагчтай алмазан өрөмдлөгийн технологийн материал* нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: *ХХ-2017/13-13*

*Эрдэнэт үйлдвэр ХХК* нь эрх бүхий тендерт оролцогчдоос *Дээж сугалагчтай алмазан өрөмдлөгийн технологийн материал* нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер 3 багцтай. Үүнд:

**Багц 1:** Алмазан хошуу

**Багц 2:** Өрөмдлөгийн яндан

**Багц 3:** Дээж сугалагчтай алмазан өрөмдлөгийн багажны бүрдэл

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2015 он, 2016 он/**

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил (2015 он, 2016 он)-ийн аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй тухайн багцын үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **100 000 000 төгрөг /нэг зуун сая/ -өөс багагүй байна.**

Тендерийн хамт санал болгож буй тухайн багцын үнийн дүнгийн **1** хувиас багагүй төгрөг, эсвэл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 50 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрхийн зөрүү: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,**

**Утас: 01-352-73371, 01-352-73787**

**Факс: 70353002**

**Вэб сайт: [www.erdenetmc.mn](http://www.erdenetmc.mn)**

**E-mail: [b.oyunchimeg@erdenetmc.mn](mailto:b.oyunchimeg@erdenetmc.mn)**